Golomt Capital®
Delivering diversity

КРИПТО

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2025.03.25

Крипто зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Ерөнхийлөгч Трампын тарифын бодлого зөөлрөх хүлээлттэй холбоотойгоор өнөөдөр Биткойны үнэ $88,000 хүрч өслөө.
- ETF-д орох хөрөнгүүд: Биткойн, Cronos (Crypto.com-ийн токен), мөн эрчим хүчний салбарын хувьцаанууд багтах аж.
- Хүртээмж: ETF-үүдийг Европ, Ази зэрэг дэлхийн зах зээлд гаргаж, томоохон брокерын платформууд болон Crypto.com апп-д (140 сая хэрэглэгчтэй) нэвтрүүлэх төлөвтэй байна.
- Тусгай онцлог: “Made in America” гэсэн сэдвийн хүрээнд АНУ-ын эдийн засгийн салбаруудтай уялдсан крипто болон хувьцааны ETF-үүдийг бүтээнэ.

Крипто мэдээ

Trump Media криптовалютын ETF гаргахаар болов. (Made in America)

Donald Trump-ын удирддаг Trump Media компани Crypto.com-той хамтран биржээр арилжаалагдах сан (ETF) болон крипто бүтээгдэхүүнүүдийг гаргах гэж буйгаа зарласны дараа тус компанийн хувьцааны үнэ огцом өсөв.

“Made in America” сэдэвт шинэ ETF-үүд

Эдгээр ETF-үүдийг Trump Media-ийн санхүүгийн технологийн брэнд "Truth.Fi" хариуцан зах зээлд гаргах бөгөөд Crypto.com болон түүний АНУ-ын охин компани Foris Capital хамтран хөгжүүлж байна.

- ETF-д орох хөрөнгүүд: Биткойн, Cronos (Crypto.com-ийн токен), мөн эрчим хүчний салбарын хувьцаанууд багтах аж.
- Хүртээмж: ETF-үүдийг Европ, Ази зэрэг дэлхийн зах зээлд гаргаж, томоохон брокерын платформууд болон Crypto.com апп-д (140 сая хэрэглэгчтэй) нэвтрүүлэх төлөвтэй байна.
- Тусгай онцлог: “Made in America” гэсэн сэдвийн хүрээнд АНУ-ын эдийн засгийн салбаруудтай уялдсан крипто болон хувьцааны ETF-үүдийг бүтээнэ.

Trump Media-ийн зах зээлийн байдал Trump Media нь Truth Social платформыг ажиллуулдаг ч 2025 онд санхүүгийн хүндхэн байдалд орсон. Компани жилийн орлого ердөө $3.6 сая байсан ч $400 саяын алдагдал хүлээжээ.

Хувьцааны үнэ он гарснаас хойш 38%-иар унасан ч энэ шинэ крипто санаачилга нь хөрөнгө оруулагчдад найдвар төрүүлж байна. Хэрэв зохицуулагч байгууллагуудаас зөвшөөрөл авбал Trump Media-ийн ETF-үүд энэ оны сүүлчээр зах зээлд гарах төлөвтэй.

БИТКОЙН - BTC

Биткойны ханш 50 хувийн дэмжлэг дээр амжилттай тогтоолоо. Бага цагаар үзвэл 83600 гэсэн түвшинг дээшээ сэтэлж гарсан нь хандлага эргэж байгаа эхний дохио болж байна.

ЭФИРИУМ - ETH

ETH үнэ биткойны хөдөлгөөнтэй төстэй явж байгаа ч 2021 оны дээд ханшаа хараахан эвдээгүй билээ. 2,150 USD түвшийн чухал бүс байсан боловч Crypto Summit болон биткойны нөөцтэй холбоотой мэдээгээр доош унасан. Харин зах зээл сэргэх хүртэл 1,520- 2,100 гэсэн ханшийн хооронд sideway хөдөлгөөн үүсгэх магадлалтай байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖУУД

InteractiveBrokers

ETF нэр	Товчлол	Зорилго
iShares Bitcoin Trust	IBIT	Биткойны үнийн гүйцэтгэлийг дагах
Fidelity Wise Origin Bitcoin Fund	FBTC	Биткойны үнийн гүйцэтгэлийг дагах
Grayscale Bitcoin Trust	GBTC	Биткойны үнийн гүйцэтгэлийг дагах
iShares Ethereum Trust	ETHA	Эфирийн үнийн гүйцэтгэлийг дагах
ARK 21Shares Active Bitcoin Ethereum Strategy ETF	ARKY	Биткойн болон Эфирийн фьючерс гэрээнүүдэд хөрөнгө оруулах
Bitwise 10 Crypto Index Fund	BITW	Тэргүүлэгч 10 криптовалютын үнийн гүйцэтгэлийг дагах
Amplify Transformational Data Sharing ETF	BLOK	Блокчэйн технологийг хөгжүүлж буй компаниудад хөрөнгө оруулах
Siren Nasdaq NexGen Economy ETF	BLCN	Блокчэйн технологийг ашиглаж буй компаниудын гүйцэтгэлийг дагах
First Trust Indxx Innovative Transaction & Process ETF	LEGR	Блокчэйн дэд бүтэц, технологид суурилсан компаниудад хөрөнгө оруулах

Disclaimer | Хариуцлагын мэдэгдэл

Энэхүү тайлан нь зөвхөн мэдээллийн зориулалттай бөгөөд хөрөнгө оруулалтын зөвлөгөө, санхүүгийн зөвлөмж биш юм. Энэхүү мэдээлэл нь зах зээлийн нөхцөл байдал, олон нийтийн эх сурвалж, найдвартай гэж үзсэн мэдээлэлд тулгуурласан боловч түүний үнэн зөв байдал, бүрэн бүтэн байдал, найдвартай байдлыг баталгаажуулах боломжгүй.

Криптовалют болон холбогдох санхүүгийн хэрэгслүүд нь өндөр эрсдэлтэй, үнэ нь зах зээлийн өөрчлөлт, зохицуулалтын өөрчлөлт, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, бусад олон хүчин зүйлээс хамаарч огцом савлагаанд орж болзошгүй. Өнгөрсөн гүйцэтгэл нь ирээдүйн үр дүнг баталгаажуулахгүй бөгөөд аливаа хөрөнгө оруулалт нь эрсдэл дагуулдаг.

Хөрөнгө оруулагчид аливаа хөрөнгө оруулалт хийхээс өмнө өөрийн санхүүгийн байдал, эрсдэл даах чадвар, хөрөнгө оруулалтын зорилгоо сайтар үнэлж, мэргэжлийн санхүүгийн зөвлөхтэй зөвлөлдөхийг зөвлөж байна. Энэхүү тайлангийн агуулгад үндэслэн гаргасан аливаа шийдвэрээс үүдэн гарах хохирол, алдагдлын хариуцлагыг манай байгууллага хүлээхгүй болно.